



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/06

Зуунмод

Горон тооны бус зөвлөл байгуулах тухай

“Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг Монгол улсын “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 674 дүгээр тушаал, 2015 оны Б/99 дүгээр тушаал “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код 136/-ын 136.4.2-ын “а”, “з” дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” “Эрэн сурвалжлах ажил” /код 229/-ын 229.11.3-ийн “б” дэх заалтын дагуу тус Цагдаагийн газрын дэргэд эрэн сурвалжилж байгаа хүн, мал, эд зүйлийг олж тогтоох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Цагдаагийн газрын эрэн сурвалжлах ажлын чиглэлээр хийсэн ажлын үр дүнг 14 хоног тутам орон тооны бус зөвлөлөөрөө хэлэлцэн арга хэмжээ тооцож байхыг орон тооны бус зөвлөлийн дарга /цагдаагийн дэд хурандаа О.Батбаатар/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Анхбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.


ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



А. БАТБАЯР

Tushaal
45000027

Цагдаагийн газрын даргын 2016 оны
02 дугаар сарын 25-ны өдрийн А/06 тоот
тушаалын хавсралт



ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Орон тооны бус зөвлөлийн дарга:

-О.Батбаатар-Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Нарийн бичгийн дарга:

-М.Баасанхүү-Эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад

Гишүүд:

-Р.Ариунболд-Заамар сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа,

-Ю.Чулуунбаатар-Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч,

-Б.Батбаяр-Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа,

-Т.Лхагвасүрэн-Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа,

-Н.Доржбалжид-Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн хошууч,

-А.Зандан-Ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч,

-Ж.Батмөнх-Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч,

-Д.Доржтайван- Заамар сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах хэсгийн дарга, цагдаагийн хошууч

-Х.Батсүх- Заамар сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад.

ЦАГДААГИЙН ГАЗАР